



ДАРХАН УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
С.НАСАНБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 03/98 УАА/2013/65-СТА-ТӨУГ

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Дулаан шарын гол” ТӨХК-ий 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дархан Шарын гол сумын Эрүүл мэндийн төв ашигласан ус дулааны төлбөр 2007-2011 оны 267,3 сая, 2012 оны 447,2 сая төгрөгийг данс бүртгэлд өглөгөөр тусган барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээрх зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 7 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дархан Уул аймгийн Төрийн сан, санхүүгийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан, ерөнхий нягтлан бодогч Д.Жаргалсайхан, Дархан Шарын гол сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Гэрэлмаа, нягтлан бодогч Ц.Алтанцэцэг, Дулаан шарын гол” ТӨХК-ий захирал Б.Энхцэцэг, ерөнхий нягтлан бодогч П.Сүнжидмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**

**СИ ЭС АЙ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ**

**Л.ОДГЭРЭЛ**

**М.СЭВЖИДМАА**

